



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар A/631

Арвайхээр

Г

Г

Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн гэрээ шууд байгуулах 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хархорин суманд баригдаж буй 250 хүний суудалтай Соёлын төвийн барилгын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Харшийн гэгээ" ХХК-ийн гүйцэтгэж буй тендерийн тоо хэмжээнд тусгагдаагүй 50тн арматур, 197м дулааны шугамын ажлыг нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.
2. Нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д даалгасугай.
3. Нэмэлт ажилд шаардагдах 189.310 091 (Нэг зуун наян есөн сая гурван зуун арван мянга ерэн нэг) төгрөгийг Сангийн яаманд уламжлан тендерийн зөрүү зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101165